

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн хяналт шалгалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/229/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2025 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд  
Утас: 7000-7734 Цахим хаяг: [boldch@audit.gov.mn](mailto:boldch@audit.gov.mn)

Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [tuvshinbayarkh@audit.gov.mn](mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn)

Аудитын менежер: Д.Отгонбаяр  
Утас: 315558 Цахим хаяг: [otgonbayarda@audit.gov.mn](mailto:otgonbayarda@audit.gov.mn)

Аудитор: Д.Баасанням  
Утас: 325093 Цахим хаяг: [baasannyamd@audit.gov.mn](mailto:baasannyamd@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/265  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ  
ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА  
С.ЭНХБАЯР ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн хяналт шалгалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь эрх бүхий улсын байцаагч нарын хяналт шалгалт хийсэн объектын бүртгэлийг цахимаар хөтлөх, мэдээллийн сан үүсгэх, бүртгэлийг хялбаршуулах, байршил, тоон үзүүлэлт, үр дүнг тайлагнах боломжтой гар утас болон вебд суурилсан аппликейшн хөгжүүлэх ажлыг эхлүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Төсвийн шууд захирагч нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлэл байршуулаагүй, тайлант оны худалдан авалтын захиалга хүсэлт өгөөгүй цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

### Бусад асуудал

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 24 зорилтын хүрээнд 64 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, 95.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## Хоёр.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>121,817,265.00</b>	<b>134,507,850.00</b>
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	<b>0.00</b>	<b>83,090,000.00</b>
34600	Урьдчилж гарсан зардал	0.00	83,090,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>121,817,265.00</b>	<b>51,417,850.00</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>65,259,800.00</b>	<b>30,326,990.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	65,259,800.00	30,326,990.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>56,557,465.00</b>	<b>21,090,860.00</b>
35410	Бичиг хэргийн материал	724,875.00	1,523,060.00
35420	Аж ахуйн материал	4,928,190.00	707,900.00
35440	Түлш, шатах тослох материал	6,170,000.00	3,735,000.00
35470	Бусад хангамжийн материал	44,734,400.00	15,124,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>420,062,950.67</b>	<b>495,959,420.15</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>420,062,950.67</b>	<b>495,959,420.15</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>142,736,884.79</b>	<b>495,959,420.15</b>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	151,625,000.00	132,250,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-75,938,280.24	-82,406,770.02
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	377,255,160.20	647,996,543.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-340,181,505.62	-349,629,692.93
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,249,052.49	141,313,768.21
39208	Хуримтлагдсан элэгдэл	-31,272,542.04	-33,414,428.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	0.00	39,850,000.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>277,326,065.88</b>	<b>0.00</b>
39301	Програм хангамж	1,430,000.00	1,430,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,430,000.00	-1,430,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	564,860,834.00	0.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-287,534,768.12	0.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>541,880,215.67</b>	<b>630,467,270.15</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>541,880,215.67</b>	<b>630,467,270.15</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>541,880,215.67</b>	<b>630,467,270.15</b>
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>541,880,215.67</b>	<b>630,467,270.15</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	562,527,716.97	541,880,215.67
51220	Тайлант үеийн үр дүн	-20,647,501.30	88,587,054.48
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>541,880,215.67</b>	<b>630,467,270.15</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,363,016,543.21</b>	<b>2,702,015,231.02</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>79,829,779.37</b>	<b>150,889,960.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>79,829,779.37</b>	<b>150,889,960.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	65,720,564.37	150,889,960.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	14,109,215.00	0.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,283,186,763.84</b>	<b>2,551,125,271.02</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>577,311,694.00</b>	<b>39,850,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	577,311,694.00	39,850,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,705,875,069.84</b>	<b>2,511,275,271.02</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,705,875,069.84	2,511,275,271.02
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,383,664,044.51</b>	<b>2,425,393,128.05</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,383,664,044.51</b>	<b>2,425,393,128.05</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,176,426,185.21</b>	<b>2,315,812,856.05</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,564,832,058.20</b>	<b>1,750,480,488.88</b>
210101	Үндсэн цалин	1,003,501,205.76	1,064,479,764.88
210102	Нэмэгдэл	211,843,075.00	281,414,211.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	160,109,530.44	264,252,737.00
210104	Урамшуулал	189,378,247.00	140,333,776.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>204,688,338.24</b>	<b>218,496,844.42</b>
210201	Тэтгэврийн даатгал	146,066,434.80	150,720,341.93
210202	Тэтгэмжийн даатгал	15,196,306.58	17,731,804.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,003,045.36	8,897,881.96
210204	Ажилгүйдлийн даатгал	2,856,592.10	8,131,709.06
210205	Эрүүл мэндийн даатгал	28,565,959.40	33,015,106.61
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,510,520.00</b>	<b>28,840,224.00</b>
210304	Байрны түрээс	24,510,520.00	28,840,224.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,252,179.10</b>	<b>106,456,622.72</b>
210401	Бичиг хэрэг	14,400,420.00	15,366,885.00
210402	Тээвэр, шатахуун	11,132,085.00	21,255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,502,969.10	10,483,052.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,192,990.00	2,973,120.00
210408	Бараа материал акталсны зардал	15,023,715.00	36,680,065.00

**Нийслэлийн хяналт шалгалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210409	<u>Бараа материал шилжүүлсний зардал</u>	<u>0.00</u>	<u>19,698,500.00</u>
<b>2106</b>	<b><u>Эд хогшил, урсгал засварын зардал</u></b>	<b><u>6,036,600.00</u></b>	<b><u>22,835,200.00</u></b>
210601	<u>Багаж, техник, хэрэгсэл</u>	<u>0.00</u>	<u>3,050,000.00</u>
210603	<u>Хөдөлмөр хамгааллын хэрэглэл</u>	<u>19,500.00</u>	<u>0.00</u>
210604	<u>Урсгал засвар</u>	<u>6,017,100.00</u>	<u>19,785,200.00</u>
<b>2108</b>	<b><u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</u></b>	<b><u>159,945,174.00</u></b>	<b><u>23,337,332.00</u></b>
210801	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж</u>	<u>156,160,090.00</u>	<u>15,234,310.00</u>
210803	<u>Даатгалын үйлчилгээ</u>	<u>267,300.00</u>	<u>410,400.00</u>
210804	<u>Тээврийн хэрэгслийн татвар</u>	<u>329,784.00</u>	<u>313,732.00</u>
210805	<u>Тээврийн хэрэгслийн оношилгоо</u>	<u>178,000.00</u>	<u>99,000.00</u>
210806	<u>Мэдээлэл, технологийн үйлчилгээ</u>	<u>1,325,000.00</u>	<u>725,000.00</u>
210809	<u>Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх</u>	<u>1,685,000.00</u>	<u>6,554,890.00</u>
<b>2109</b>	<b><u>Бараа үйлчилгээний бусад зардал</u></b>	<b><u>166,161,315.67</u></b>	<b><u>165,366,144.03</u></b>
210901	<u>Бараа үйлчилгээний бусад зардал</u>	<u>0.00</u>	<u>9,698,300.00</u>
210902	<u>Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх</u>	<u>3,885,000.00</u>	<u>5,055,000.00</u>
210903	<u>Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол</u>	<u>162,276,315.67</u>	<u>150,612,844.03</u>
<b>213</b>	<b><u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</u></b>	<b><u>207,237,859.30</u></b>	<b><u>109,580,272.00</u></b>
<b>2132</b>	<b><u>Бусад урсгал шилжүүлэг</u></b>	<b><u>103,885,688.00</u></b>	<b><u>109,580,272.00</u></b>
213207	<u>Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж</u>	<u>97,645,688.00</u>	<u>39,427,157.00</u>
213209	<u>Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал</u>	<u>6,240,000.00</u>	<u>70,153,115.00</u>
<b>2134</b>	<b><u>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</u></b>	<b><u>103,352,171.30</u></b>	<b><u>0.00</u></b>
213405	<u>Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг</u>	<u>103,352,171.30</u>	<u>0.00</u>
<b>III</b>	<b><u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</u></b>	<b><u>-20,647,501.30</u></b>	<b><u>276,622,102.97</u></b>
<b>V</b>	<b><u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</u></b>	<b><u>0.00</u></b>	<b><u>188,035,048.49</u></b>
225001	<u>Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз</u>	<u>0.00</u>	<u>188,035,048.49</u>
<b>VI</b>	<b><u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</u></b>	<b><u>-20,647,501.30</u></b>	<b><u>88,587,054.48</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,283,186,763.84</b>	<b>2,551,125,271.02</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,283,186,763.84</b>	<b>2,551,125,271.02</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>577,311,694.00</b>	<b>39,850,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	577,311,694.00	39,850,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,705,875,069.84</b>	<b>2,511,275,271.02</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,705,875,069.84	2,511,275,271.02
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,283,186,763.84</b>	<b>2,472,626,771.02</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,283,186,763.84</b>	<b>2,472,626,771.02</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,075,948,904.54</b>	<b>2,363,046,499.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,564,832,058.20</b>	<b>1,750,480,488.88</b>
210101	Үндсэн цалин	1,003,501,205.76	1,055,554,764.88
210102	Нэмэгдэл	211,843,075.00	281,414,211.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	160,109,530.44	273,177,737.00
210104	Урамшуулал	189,378,247.00	140,333,776.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>204,688,338.24</b>	<b>218,496,844.42</b>
210201	Тэтгэврийн даатгал	146,066,434.80	150,720,341.93
210202	Тэтгэмжийн даатгал	15,196,306.58	17,731,804.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,003,045.36	8,880,245.36
210204	Ажилгүйдлийн даатгал	2,856,592.10	8,149,345.66
210205	Эрүүл мэндийн даатгал	28,565,959.40	33,015,106.61
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,510,520.00</b>	<b>28,840,224.00</b>
210304	Байрны түрээс	24,510,520.00	28,840,224.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,901,954.10</b>	<b>48,785,057.72</b>
210401	Бичиг хэрэг	13,605,810.00	15,254,585.00
210402	Тээвэр, шатахуун	16,802,085.00	18,820,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,502,969.10	10,483,052.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,991,090.00	4,227,420.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,356,200.00</b>	<b>280,955,002.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	143,931,223.00
210602	Тавилга	0.00	45,613,579.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	9,415,100.00	73,090,000.00
210604	Урсгал засвар	6,941,100.00	18,320,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>220,774,834.00</b>	<b>8,455,582.00</b>

**Нийслэлийн хяналт шалгалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210803	Даатгалын үйлчилгээ	267,300.00	410,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	329,784.00	313,732.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	178,000.00	159,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,391,000.00	725,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,775,560.00	6,847,450.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,885,000.00</b>	<b>27,033,300.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	21,978,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,885,000.00	5,055,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>207,237,859.30</b>	<b>109,580,272.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>103,885,688.00</b>	<b>109,580,272.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	97,645,688.00	86,319,322.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,240,000.00	23,260,950.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>103,352,171.30</b>	<b>0.00</b>
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	103,352,171.30	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>0.00</b>	<b>78,498,500.00</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>8,990,000.00</b>	<b>78,498,500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,990,000.00</b>	<b>78,498,500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,990,000.00</b>	<b>78,498,500.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	78,498,500.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-8,990,000.00</b>	<b>-78,498,500.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>-8,990,000.00</b>	<b>0.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,990,000.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	562,527,716.97	562,527,716.97
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	562,527,716.97	562,527,716.97
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00

6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	-20,647,501.30	-20,647,501.30
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,880,215.67	541,880,215.67
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	541,880,215.67	541,880,215.67
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	541,880,215.67	541,880,215.67
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	88,587,054.48	88,587,054.48
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	630,467,270.15	630,467,270.15

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,633,605,800.00</b>	<b>2,511,275,271.02</b>	<b>1,122,330,528.98</b>	69.11
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,633,605,800.00</b>	<b>2,511,275,271.02</b>	<b>1,122,330,528.98</b>	69.11
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,523,225,400.00</b>	<b>2,401,694,999.02</b>	<b>1,121,530,400.98</b>	68.17
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,591,825,900.00</b>	<b>1,750,480,488.88</b>	<b>841,345,411.12</b>	67.54
Үндсэн цалин	1,294,299,000.00	1,055,554,764.88	238,744,235.12	81.55
Нэмэгдэл	497,480,900.00	281,414,211.00	216,066,689.00	56.57
Унаа хоолны хөнгөлөлт	513,700,000.00	273,177,737.00	240,522,263.00	53.18
Урамшуулал	286,346,000.00	140,333,776.00	146,012,224.00	49.01
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>358,272,000.00</b>	<b>218,496,844.42</b>	<b>139,775,155.58</b>	60.99
Тэтгэврийн даатгал	243,625,000.00	150,720,341.93	92,904,658.07	61.87
Тэтгэмжийн даатгал	28,661,700.00	17,731,804.86	10,929,895.14	61.87
ҮОМШӨ-ний даатгал	23,857,100.00	8,880,245.36	14,976,854.64	37.22
Ажилгүйдлийн даатгал	4,804,700.00	8,149,345.66	-3,344,645.66	169.61

**Нийслэлийн хяналт шалгалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Эрүүл мэндийн даатгал	57,323,500.00	33,015,106.61	<b>24,308,393.39</b>	57.59
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>46,651,700.00</b>	<b>28,840,224.00</b>	<b>17,811,476.00</b>	61.82
Байрны түрээс	46,651,700.00	28,840,224.00	<b>17,811,476.00</b>	61.82
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>53,923,600.00</b>	<b>48,785,057.72</b>	<b>5,138,542.28</b>	90.47
Бичиг хэрэг	15,145,600.00	15,254,585.00	<b>-108,985.00</b>	100.72
Тээвэр, шатахуун	18,943,000.00	18,820,000.00	<b>123,000.00</b>	99.35
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	15,600,000.00	10,483,052.72	<b>5,116,947.28</b>	67.20
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,235,000.00	4,227,420.00	<b>7,580.00</b>	99.82
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>434,873,200.00</b>	<b>319,603,502.00</b>	<b>115,269,698.00</b>	73.49
Багаж, техник, хэрэгсэл	247,092,900.00	143,533,723.00	<b>103,559,177.00</b>	58.09
Тавилга	86,175,300.00	84,659,579.00	<b>1,515,721.00</b>	98.24
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	83,250,000.00	73,090,000.00	<b>10,160,000.00</b>	87.80
Урсгал засвар	18,355,000.00	18,320,200.00	<b>34,800.00</b>	99.81
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,029,000.00</b>	<b>8,455,582.00</b>	<b>1,573,418.00</b>	84.31
Даатгалын үйлчилгээ	600,000.00	410,400.00	<b>189,600.00</b>	68.40
Тээврийн хэрэгслийн татвар	379,000.00	313,732.00	<b>65,268.00</b>	82.78
Тээврийн хэрэгслийн оношлогоо	510,000.00	159,000.00	<b>351,000.00</b>	31.18
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	725,000.00	725,000.00	<b>0.00</b>	100.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,815,000.00	6,847,450.00	<b>967,550.00</b>	87.62
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>27,650,000.00</b>	<b>27,033,300.00</b>	<b>616,700.00</b>	97.77
Бараа үйлчилгээний бусад зардал	22,000,000.00	21,978,300.00	<b>21,700.00</b>	99.90
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,650,000.00	5,055,000.00	<b>595,000.00</b>	89.47
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>110,380,400.00</b>	<b>109,580,272.00</b>	<b>800,128.00</b>	99.28

<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>110,380,400.00</b>	<b>109,580,272.00</b>	<b>800,128.00</b>	99.28
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	86,380,400.00	86,319,322.00	<b>61,078.00</b>	99.93
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,000,000.00	23,260,950.00	<b>739,050.00</b>	96.92
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,633,605,800.00</b>	<b>2,511,275,271.02</b>	<b>1,122,330,528.98</b>	69.11
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>3,633,605,800.00</b>	<b>2,511,275,271.02</b>	<b>1,122,330,528.98</b>	69.11
Орон нутгийн төсвөөс	3,633,605,800.00	2,511,275,271.02	<b>1,122,330,528.98</b>	69.11

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	39,850,000.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	39,850,000.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	39,850,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	39,850,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл, тавилга	39,860,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	39,850,000.00
<b>1320</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	39,850,000.00
131104	Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх	39,850,000.00

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт 1,705,308.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангаас төвлөрүүлэх шилжүүлгийн 1,082,480.5 мянган төгрөгийн зардлыг тохируулга хийж, төсвийн гүйцэтгэлийг цэвэр дүнгээр тайлагнаагүй;
- Цалингийн урьдчилгааг цалингийн зардалд 622,827.8 мянган төгрөгөөр бууруулж бүртгэсэн.

Аудитаар нийт 13,195.7 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 4,202.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 8,793.5 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 13,197.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

### 5.1 Албан шаардлага

**Илрүүлэлт:** Жилийн эцэст нийт албан хаагчдад 4,202.2 мянган төгрөгийн шагналыг хавтгайруулан олгож, төсвийг үрэлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалын данстай холбоотой асуудал

Тооллогын комисс санал болгоогүй, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлээгүй байхад бараа материал акталж, данс бүртгэлээс хассан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахад дараах журмыг баримтална: 1/ худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

**Өгсөн зөвлөмж:** Тооллогын комисс санал болгосон, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлэсэн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хасч байх зөвлөмж өгөв.

#### 2. Зардлын данстай холбоотой асуудал

Бүрдэл дутуу анхан шатны баримтаар 1,200.0 мянган төгрөгийн гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно., 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/			
							Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн гүйлгээний тайлангаас төвлөрүүлэх шилжүүлгийн зардлыг тохируулга хийж, төсвийн гүйцэтгэлийг цэвэр дүнгээр тайлагнаагүй байна.	1	1,082,480.5			1	1,082,480.5	1	1,082,480.5		
Цалингийн урьдчилгааг цалингийн зардалд бууруулж бүртгэсэн.	1	622,827.8			1	622,827.8	1	622,827.8		
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,705,308.3</b>			<b>2</b>	<b>1,705,308.3</b>	<b>2</b>	<b>1,705,308.3</b>		

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тооллогын комисс санал болгоогүй, өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцэж шийдвэрлээгүй байхад бараа материал акталж, данс бүртгэлээс хассан.	1	7,593.5					1	7,593.5				
Жилийн эцэст нийт албан хаагчдад шагнал олгосон байна.	1	4,402.2			1	4,402.2						

Анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгасан,	1	1,200.0					1	1,200.0				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>13,195.7</b>			<b>1</b>	<b>4,402.2</b>	<b>2</b>	<b>8,793.5</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 319,168.5 мянган төгрөгийн 18 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	319,168.5					1	319,168.5				
Төсвийн хөрөнгөөр бараа худалдан авахдаа цахим дэлгүүрээс худалдан аваагүй байна.	1	324,787.2					1	324,787.2				
Үндсэн хөрөнгө бэлтгэхдээ шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан.	1	94,496.5			1	94,496.5						
Тайлант онд албан хаагчдад ажлын хувцас олгох хэрэгцээ шаардлага үүсээгүй байхад ажлын хувцас худалдан авах гэрээг байгуулж, гэрээт ажлын төлбөрийг гэрээний "бүрэн гүйцэт ажил дууссаны дараа гэрээг дүгнэж төлбөрийг олгоно"	1	73,090.0			1	73,090.0						

гэсэн заалтыг хэрэгжүүлэлгүй төлбөрийг 100 хувь урьдчилан төлж авлага үүсгэсэн.												
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>811,542.2</b>			<b>1</b>	<b>167,586.5</b>	<b>2</b>	<b>643,955.7</b>				

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	6	7	8	9
1	ТШЗ	1	1			1			
	Нийт	1	1			1			

